



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 06


Улаанбаатар хот

Зохион байгуулалтын арга
хэмжээ авах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтын 8.1.1, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2014 оны “Комисс байгуулах тухай” 07 дугаар захирамж, Монгол улсын Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал, Эрүүл мэндийн сайд, Үндэсний статистикийн хорооны даргын “Хамтарсан ажлын хэсэг байгуулах тухай” 2014 оны А/ 112/366/А 128 дугаар тушаал, Үндэсний статистикийн хорооны даргын 2014 оны “Монгол улсын гурван сая дахь иргэнийг тодруулах журам, шуурхай бүртгэлийн маягт батлах тухай” А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсын гурван сая дахь иргэнийг тодруулахад төрөлтийг бүртгэх, мэдээлэх, эх, нярайд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх удирдамжийг нэгдүгээр, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, үйл ажиллагааны төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Монгол улсын гурван сая дахь иргэнийг тодруулах бэлтгэл ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Ганчимэг/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү удирдамжийг мөрдөн ажиллахыг төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, амаржих газар, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд сайд Д.Атармаад даалгасугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080021

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 01 сарын 08 өдрийн
06 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

**“МОНГОЛ УЛСЫН ГУРВАН САЯ ДАХЬ ИРГЭНИЙГ ТОДРУУЛАХАД
ТӨРӨЛТИЙГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ, ЭХ НЯРАЙД ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ УДИРДАМЖ**

Нэг. Үндэслэл.

Монгол улс 1962 оны 10 дугаар сард 1 сая, 1988 оны 07 дугаар сард 2 сая хүн амтай болсон байна. Монгол улсын хүн ам 2013 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 2931277 байсан бол 2014 онд Монгол улсад 81715, гадаад оронд 1121 хүүхэд төрснөөр өнгөрсөн оны 12 дугаар сарын 31-ны байдлаар нийт хүн амын тоо 2995949 болжээ.

Монгол улсын Үндэсний статистикийн хорооноос 2015 оны нэгдүгээр сард Монгол улсын гурван сая дахь иргэн төрнө гэдгийг мэдээлсэн.

Хоёр. Зорилго

Монгол улсын гурван сая дахь иргэнийг тодруулахад төрөлтийг зөв бүртгэх, мэдээлэх, эх, нярайд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх стандартыг чанд мөрдөн ажиллах, ээлтэй орчин бүрдүүлэхэд онцгой анхаарал хандуулан ажиллахад чиглэнэ.

Гурав. Хугацаа

2015 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 3 сая дахь иргэн төрөх хүртэлх хугацаанд мөрдөнө.

1. Төрөлтийг бүртгэх, мэдээлэхэд анхаарах зүйл:

- Төрөлтийг бүртгэх, хяналт тавих, мэдээлэх ажлыг тухайн эмнэлэг бүр зохион байгуулна.
- Төрөлтийг хуанлын өдрөөр тооцож, өдөр бүрийн 00.00 цагт тасалбар болгоно.
- Зөвхөн амьд төрөлтийг (төрсөн эх болон хүүхдийн тоо) бүртгэж, мэдээлнэ.
- “Төрөлтийн дэлгэрэнгүй бүртгэлийн маягт” –аар мэдээлэл авах зөвшөөрөгдсөн өдрөөс эхлэн төрөлтийг маягтын дагуу дэлгэрэнгүй бүртгэж мэдээлнэ.
- Төрсөн цагийг Улаанбаатар хотын цагаар тооцох учир цагийн зөрүүтэй аймгууд хүүхдийн төрсөн цагийг орон нутгийн цагаар болон Улаанбаатар хотын цагаар гэж бичиж мэдээлнэ.
- Төрөх өрөөний цагийг Стандарт хэмжилзүйн газрын цагаар тохируулна.
- Нярайд төрмөгц төрсөн цаг, минут, секундыг чанга дуугаар эхэд хэлж, төрөлтийн түүхэнд тэмдэглэнэ.
- Төрөлтийн түүх, нярайн түүх, төрөлтийн дэлгэрэнгүй бүртгэлийн маягт, гурван сая дахь иргэнийг тодруулахад ашиглах эх, хүүхдийн мэдээлэл дээр эхийн

- овог, нэр, нас, хүүхэд төрсөн сар, өдөр, цаг, минут, секунд, нярайн, Апгарын үнэлгээг цэвэр гаргацтай, засваргүй, зөрөөгүй бичнэ.
- Төрөлтийн мэдээг эмнэлгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулснаар дүн бүртгэлийн ажилтан харъяа аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дүн бүртгэлийн алба, хэлтэст дараа өдрийн 09 цагаас өмнө хүргүүлнэ.
 - Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эмнэлгүүдийн мэдээг нэгтгэж, нэгдсэн мэдээг 2 хувь үйлдэж, баталгаажуулан, нууцлалыг ханган, аймаг, нийслэлийн Статистикийн газар, хэлтэст өдөр бүрийн 11.00 цагаас өмнө хүргүүлнэ.

2.Эх, нярайд үзүүлэх тусламж үйлчилгээнд анхаарах зүйл:

2.1. Жирэмсэн үед үзүүлэх тусламж, үйлчилгээ

- Харъяаллын бус, шилжиж ирсэн жирэмсэн эмэгтэйд хүндрэл учруулахгүй, оршин суугаа байршилд ойрхон эмнэлэгт тусламж үзүүлнэ.
- Хяналтанд байгаа нэгдүгээр сард төрөх эхчүүдийн бүртгэлийг урьдчилан төрөх өдрөөр нь гаргаж, шинжилгээ бүрэн хийгдсэн, солилцох хуудас олгогдсон эсэхийг нягтлан, товлолын дагуу үзэж, төрөлтийн төлөвлөгөөг гаргана.
- Эх, ургийн талаас хүндрэлтэй эхийг төрөхөөс өмнө хэвтүүлж, төрөлтийн төлөвлөгөөг боловсруулсан байна.
- Дутуу төрөхийг завдаж буй эмэгтэйчүүдэд удирдамжийн дагуу тусламж, үйлчилгээ үзүүлнэ.
- Амьгүй төрөлт, гэрийн төрөлтөөс сэргийлэх талаар жирэмсэн эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.
- Алслагдсан нутагт амьдарч байгаа жирэмсэн эмэгтэйчүүдийг төрөхийн өмнө эхийн амрах байранд амруулах, өндөр эрсдэлтэй жирэмсэнг нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг, амаржих газарт илгээнэ.

2.2 Төрөх үед үзүүлэх тусламж, үйлчилгээ

- Төрөлтийн тусламж, үйлчилгээний стандарт, удирдамж, заавар, журмыг мөрдөн ажиллана.
- Төрөлтийн үеийн тусламжийг багаар (эх барих, эмэгтэйчүүд, нярайн эмч, сумын эмч, эх баригч, сувилагч, бусад шаардлагатай мэргэжлийн эмч) үзүүлнэ.
- Нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлийн эмч дагнан тусламж үзүүлнэ. (Жижүүрийн хугацаанд бусад мэргэжлийн эмчийг гаргахгүй)
- Төрөх өрөөнд заавал цагтай байна.
- Төрөх өрөөнд хяналтын камертай эмнэлгүүд бичлэг хийж, баримтжуулна.
- Тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллана. (эм, тариа, цус цусан бүтээгдхүүн, эмнэлгийн хэрэгсэл)
- Халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан ажиллана.
- Төрсөн нярай бүрт нэн шаардлагатай тусламжийг үзүүлнэ.
- Нярайн Апгарын үнэлгээг төрүүлсэн эмч, нярайн эмч нар харилцан зөвшилцөж нэг үнэлгээ өгнө.

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны .01. сарын .08. өдрийн
.06. дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

МОНГОЛ УЛСЫН ГУРВАН САЯ ДАХЬ ИРГЭНИЙГ ХҮЛЭЭН АВАХ
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн дарга: Г.Ганчимэг, Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
- Ажлын хэсгийн орлогч дарга: Л.Зэндмаа, Эмнэлгийн тусламжийн хэлтсийн /ЭТХ/ даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
- Нарийн бичгийн дарга: Н.Болормаа, ЭТХ-ийн мэргэжилтэн
- Гишүүд:
- О.Баяр, Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
- Э.Оюунсүрэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
- М.Уранчимэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
- Г.Соёлгэрэл, ЭТХ-ийн мэргэжилтэн
- Б.Пүрэвжав, ЭТХ-ийн мэргэжилтэн
Д.Баясгалан, ХШҮДАГ-ын мэргэжилтэн
- Т.Эрхэмбаатар, Эх барих, эмэгтэйчүүдийн ерөнхий мэргэжилтэн
- Б.Баясгалантай, Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн
- Ч.Бат-Эрдэнэ, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал
- Б.Баттулга, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн /ЭХЭМҮТ/ Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгийн захирал

Ц.Алтантуяа, ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн
захирал

С.Хишгээ, ЭХЭМҮТ-ийн зөвлөх эмч

Р.Октябрь, Нийслэлийн эрүүл мэндийн газрын
мэргэжилтэн



Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 01 сарын 08 өдрийн
06 дугаар тушаалын 3 дугаар
хавсралт

МОНГОЛ УЛСЫН ГУРВАН САЯ ДАХЬ ИРГЭНИЙГ ХҮЛЭЭН
АВАХ БЭЛТГЭЛ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Давтамж	Хариуцах ажилтан	Хэрэгжүүлэх байгууллага
1.	Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай тушаал боловсруулан батлуулах	01.08	1	Л.Зэндмаа, ЭТХ-ийн ДАУТОГ Н.Болормаа, ЭТХ-ийн мэргэжилтэн	Эрүүл мэндийн байгууллага
2.	Төрөлтийн дэлгэрэнгүй бүртгэлийн маягт боловсруулахад санал өгөх	01.08	1	Л.Зэндмаа, ЭТХ-ийн ДАУТОГ	Ажлын хэсэг, мэргэжлийн баг
3.	Монгол улсын гурван сая дахь иргэнийг тодруулахтай холбоотой мэдээлэл, бэлтгэл ажлын чиглэлээр цахим хурал зохион байгуулах	01.08 01.13 01.16	3	Н.Болормаа, ЭТХ-ийн мэргэжилтэн Б.Пүрэвжав, ЭТХ-ийн мэргэжилтэн	ЭМХТ, АНЭМГ
4.	Төрөлтийн бүртгэлийн үнэн, зөв байдал, мэдээллийн урсгалд хяналт тавьж ажиллах	1 сард	байнга	Ч. Бат- Эрдэнэ, ЭМХТ-ийн захирал	Эрүүл мэндийн байгууллага
5.	Тусламж, үйлчилгээний чиглэлээр сургалт зохион байгуулах	1 сард	тогтмол	Н.Болормаа, ЭТХ-ийн мэргэжилтэн	ЭХЭМҮТ, АНЭМГ, БОЭТ, НЭ, амаржих гэзар, ДЭМТ
6.	ЭХЭМҮТ, нийслэлийн амаржих газрын эмч мэргэжилтнүүдийг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах	01.13 01.14 01.15	4	Н.Болормаа, ЭТХ-ийн мэргэжилтэн Р.Октябрь, НЭМГ-ын мэргэжилтэн	ЭХЭМҮТ, нийслэлийн амаржих газрууд
7.	Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн ЭЭОД, чанарын менежерүүдэд мэдээлэл хийх	01.10	1	Л.Зэндмаа, ЭТХ-ийн ДАУТОГ Н.Болормаа, ЭТХ-ийн мэргэжилтэн	ТЭ, ТМТ
8.	Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн асуудлыг зохицуулах	1-р сард	1	М.Уранчимэг, ЭЭХХ-ийн ДАУТОГ	Эрүүл мэндийн байгууллага

9.	Эх, нярайн тусламжийн нэг удаагийн хэрэгсэл хуваарилах тушаал гарган, түгээх	01.10	1	Н.Болормаа, ЭТХ-ийн мэргэжилтэн
10.	Эх баригч нарт зориулсан сургалт зохион байгуулах		2	Н.Болормаа, ЭТХ-ийн мэргэжилтэн

